



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 23 өдөр

Дугаар A/169

Улаанбаатар хот

### Тушаалд өөрчлөлт оруулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйлийн 232.9 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх, Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 618 дугаар тушаалын үндэслэх хэсэгт “Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйлийн 232.9, Улсын гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь” гэж заасныг “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 232 дугаар зүйлийн 232.9 дэх хэсэг, 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь” болгож өөрчилсүгэй.

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Ё.Бат-Эрдэнэ/, Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Гэндэнцэвээн/, Зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар /Б.Онон/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АСРАЛТ



0001303